

Монгол Улс болон БНХАУ-ын хооронд **АЮУЛТАЙ АЧАА** тээвэрлэхэд бүрдүүлэх бичиг баримтын жагсаалт

Улс хооронд аюултай ачаа тээвэрлэх тохиолдолд АТҮТ-д албан хүсэлт гаргах бөгөөд Албан хүсэлтэд тээврийн маршрут, хугацаа болон тээвэрлэх бараа бүтээгдэхүүний төрөл, олон улсын нэршил, томъёог оруулан хавсралтаар дараах материалыг бүрдүүлнэ. Үүнд:

1. Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар (Үйл ажиллагааны чиглэл : Гадаад худалдаа болон авто замаар ачаа тээвэрлэх)
2. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны аюултай ачаа экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, ашиглах, худалдах, устгах аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл
3. Зам, тээврийн хөгжлийн яамны Улсын байцаагчийн дүгнэлт гаргуулах (Автотээврийн үндэсний төвд Улсын байцаагчийн дүгнэлт гаргуулах тухай албан хүсэлт өгөх)
4. Тээвэрлэгч, тээвэрлүүлэгчтэй байгуулсан гэрээ
5. Худалдах, худалдан авах гэрээ

Тээврийн хэрэгсэл

6. Тээврийн хэрэгслийн гэрчилгээ, татварын хуулбар (**Үйлдвэрлэсэн огноо 10 жилээс хэтрэхгүй байх**) (**Тухайн байгууллагын нэр дээр бүртгэлтэй байх**)
7. Тээврийн хэрэгслийн фото зураг (4н талаас 45 градусын өнцгөөс бүтэн авсан байх)
8. Техникийн хяналтын оношлогоонд орсон дүгнэлтийн хуудас
9. Бүртгэлийн гэрчилгээ (Техникийн паспорт)
10. Байршил тогтоогч төхөөрөмж суурилуулсан гэрээний хуулбар (Автотээврийн үндэсний төвтэй гэрээ хийх)
11. Ачааны зураг (Шахсан хийн даралтат савны 4н талаас авсан фото зураг)
12. Даралтат савны туршилтын тайлангийн гэрчилгээ
13. Ослын карт (Ачааны олон улсын нэршил, төлөв байдал, ослын үед авах арга хэмжээ зэрэг мэдээллүүдийг оруулсан байх)

Даатгал

14. Албан журмын даатгал
15. БНХАУ-ын хуулийн дагуу
 - a. Авто замаар аюултай ачаа тээвэрлэх хариуцлагын даатгал,
 - b. Авто замаар аюултай ачаа тээвэрлэх ослын даатгалыг хийлгэсэн байх.

Жолооч

16. Гадаад паспорт
17. Жолоочийн үнэмлэх
18. Мэргэшсэн жолоочийн үнэмлэх (С, Е ангилалтай, Аюултай, урт, хүнд, овор ихтэй ачаа болон Улс хоорондын ачаа тээврээр мэргэшсэн байх)
19. Шаардлагатай тохиолдолд тухайн улсын хууль, тогтоомжид заасны дагуу нэмэлт материалыг тус тус хавсаргах;

***Тээврийн хэрэгслийн улсын дугаар, арлын дугаар, хөдөлгүүрийн дугаар зэрэг мэдээлэл болон жолоочийн овог нэр, регистрийн дугаар зэрэг дэлгэрэнгүй мэдээлийн жагсаалтыг excel.file-аар цахим хаягаар явуулах.**

Улс хоорондын байнгын ачаа тээвэрлэлт гүйцэтгэх зөвшөөрөл авахад бүрдүүлэх материал, бичиг баримт

1. Монгол Улсын Засгийн газрын байгуулсан 2 талт хэлэлцээр болон Зам, тээврийн сайдын баталсан маршрутын дагуу тээвэрлэлт гүйцэтгэнэ.
2. Уурхай эзэмшигч аж ахуй нэгж байгууллага нь өөрсдийн тээвэрлэгчийн талаарх албан бичгийг Автотээврийн үндэсний төвд ирүүлнэ.

Албан бичигт доорх бичиг баримтыг хавсаргасан байна. Үүнд:

- 2.1. Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар;
- 2.2. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны танилцуулга;
- 2.3. Удирдах болон инженер, техникийн ажилтны анкет, мэргэжлийн дипломын хуулбар;
- 2.4. Тээвэрлэлтийн маршрут, чиглэлийг тодорхойлсон зураг, түүнийг баталсан эрх бүхий байгууллагын шийдвэрийн хуулбар;
- 2.5. Ачаа илгээгч, эсхүл хүлээн авагчтай байгуулсан тээвэрлэлтийн гэрээ;
- 2.6. MNS 4598:2011. Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлагыг хангасан байх;
- 2.7. MNS 6278:2011. Хүнд даацын автотээврийн хэрэгсэл. Техникийн ерөнхий шаардлагыг хангасан байх;
- 2.8. Тээврийн хэрэгсэл бүр дээр Автотээврийн Хяналтын Улсын Байцаагчийн шалгах хуудас гаргуулсан байх;
- 2.9. Тээвэрлэлт гүйцэтгэх автотээврийн хэрэгслийн гэрчилгээний хуулбар;
- 2.10. Жолоочийн болон мэргэшсэн жолоочийн үнэмлэхний хуулбар;
- 2.11. Татвар төлөгч /НДШ, ЭМД..гэх мэт/ эсхийг тодорхойлсон баримт бичгийн хуулбар;
- 2.12. Автотээврийн хэрэгслийн техникийн бэлэн байдлыг хангах зориулалтын засвар, үйлчилгээний байгууламж, тээвэрлэлтийг гүйцэтгэх жолооч, бусад ажилчдыг байршуулах зориулалт бүхий өөрийн, эсхүл түрээсийн байртай эсэх талаарх танилцуулга /холбогдох баримтын хамт/;
- 2.13. Авто зам ашиглах гэрээ эсхүл батлагдсан маршрутын дагуу шороон замаар тээвэрлэлт гүйцэтгэх тохиолдолд тээвэрлэлтээс хүрээлэн байгаа орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний төлөвлөгөө, түүнийг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийг баталгаажуулсан баримт;
- 2.14. Шаардлагатай бол тээвэрлэлт гүйцэтгэхэд гадаадаас авах ажиллах хүчний тоо, эрх бүхий байгууллагаас олгосон хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;
- 2.15. Тээврийн хэрэгсэл бүр дээр байршил тогтоох төхөөрөмж суурилуулж, Автотээврийн үндэсний төвийн тээврийн хэрэгслийн хяналтын нэгдсэн системд холбогдсон байх

Жич:

- Холбогдох бичиг баримтын хуулбарыг нотариатаар баталгаажуулан, товъёолон дэс дарааллын дагуу үдэж хавтаслан хүргүүлэх.
- Жагсаалтанд тусгагдаагүй материалыг оруулахгүй бөгөөд нэмэлт материал шаардлагатай тохиолдолд бүрдүүлж өгөх.

**ГУРВАН УЛСЫН ДАМЖИН ӨНГӨРӨХ ТЭЭВЭРЛЭЛТ ГҮЙЦЭТГЭХ
ЗӨВШӨӨРЛИЙН БИЧИГ АВАХАД БҮРДҮҮЛЭХ
МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ**

1. Засгийн газар хоорондын хэлэлцээрээр батлагдсан маршрутаар тээвэрлэлт гүйцэтгэх аж ахуйн нэгж, хувь хүний албан хүсэлт;
2. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар /нотариатаар баталгаажуулсан/
3. Тээвэрлэлт хийх маршрут, чиглэлийг тодорхойлсон зураг /АНЗ, АН4/;
4. Ачаа илгээгч, эсхүл хүлээн авагчтай байгуулсан тээвэрлэлтийн гэрээний хуулбар;
5. Евро 4 стандарт болон түүнээс дээш ангиллын тээврийн хэрэгслээр тээвэрлэлт гүйцэтгүүлэх, тээврийн хэрэгсэл бүр дээр автотээврийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлт гаргуулах;
6. Тээвэрлэлт гүйцэтгэх тээврийн хэрэгслийн гэрчилгээний хуулбар, фото зураг /4 талаас, англи хэл дээр орчуулсан байх/;
7. Жолоочийн болон мэргэшсэн жолоочийн үнэмлэхийн хуулбар /англи хэл дээр орчуулсан байх/;
8. Иргэний үнэмлэх болон гадаад паспортын хуулбар /жолоочийн/

